



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/206

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх эрх олгох дуудлага  
худалдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, 2020 оны 152 дугаар тогтоол, 2024 оны 136 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын 13-р баг Радио өргөн нэвтрүүлэх станцын хажууд (урд) байршилтай, төлөвлөлтийн 3818152 дугаарын нэгж талбартай, 4000 м<sup>2</sup> талбайтай, 18,000,000 (Арван найман сая) төгрөгийн анхны үнэтэй, үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зориулалттай газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх эрх олгох дуудлага худалдааг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09:00-15:00 цаг хүртэл цахим хэлбэрээр ([www.mle.mn](http://www.mle.mn)) буюу газрын цахим биржээр зохион байгуулсугай.

2.Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг явуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу цахимаар зохион байгуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

